УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн

УВА-2022/30-18-ШТА –ГА

2022 оны 06 дугаар сар

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 06 өдөр Дугаар А/23 Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 5 дугаар хавсралт, 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн УВА-2022/30-18-ШТА-ГА гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Сагил сумын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор С.Батсайхан нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

020160178

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар..... 2

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....3

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 5

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.....6

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү..... . .6

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилж олгосон байна.....6-7

1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.....7-9

1.1.4. Сумдын ОНХС-д хуулийн хүрээнд нэмж 358.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.....10-11

1.2.1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумдын саналыг тусгасан эсэх нь нотлох бариmтаар тогтоогдохгүй байна.....11-12

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.....12-13

1.2.3. Аймаг, сумдын ОНХС-аас Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй 10 төсөл, арга хэмжээг тусгасан байна.....13-14

1.2.4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бусад хууль журмын хүрээнд 30.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.....14

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....15

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.....15-18

2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд 102.3 сая төгрөгийг урсгал зардалд, 9.8 сая төгрөгийг дэмжлэгт олгосон байна.....18-21

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.....21-23

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээ үр дүнгүй, 3 төсөл, арга хэмжээний үр дүн гараагүй байна.....23-24

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна.....24

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг иргэд болон хоршоонд түрээсгүйгээр ашиглуулж байна.....24-25

БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН ХЭДИЙ Ч ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....26

3.1.1. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, аймгийн ИТХ-ын хяналт хангалтгүй байна.....26-27

3.1.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хэрэгжүүлж байна.....27

3.1.3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.....27-29

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна.....29-30

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэсэн байна.....31

3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлээгүй байна.....30-31

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн байна.....31-32

ДҮГНЭЛТ: 33

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....34-36

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР.....36-38

ЗӨВЛӨМЖ:.....39

Товчилсон үгийн тайлбар

ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОУБ	Олон улсын байгууллага
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НАТ	Нөөц ашигласны төлбөр
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТА-3	Тогтвортой амьжиргаа-3
БТСГ	Биеийн тамир спортын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГБХЗХГ	Гэр, бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХШҮДАХ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АМХБАТЗ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	ОНХС-ийн 2021 оны тодотгосон төсөв	7
2	ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	8
3	Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	9
4	Аймаг сумдын ОНХС-д олгосон санхүүжилт	10
5	Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө	11-12
6	Сумдын ОНХС-д нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	12
7	Аймаг сумдын ОНХС-р батлагдсан төсөл арга хэмжээ	13-14
8	ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт	17
9	Аймаг , сумдын ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажил	21
10	Өмнөх оны аудитаар илэрсэн алдаа зөрчлийн биелэлт	29-31

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, БИНХ-ыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын арга зүйгээр хангаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батсайхан, аудитор Ч.Мөнхтогтох, Б.Энхмандал нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан цаглаварт хугацаанд Санхүүгийн тайлангийн

болон гүйцэтгэл, нийцлийн төлөвлөгөөт аудитууд зэрэг хийгдсэнээс шалтгаалан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ бүрийг газар дээр нь очиж үзэж амжаагүй болно. Аудитын хүрээнд Улаангом сум болон хөдөөгийн 9 суманд очиж ажилласан бөгөөд бусад сумдад хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн фото зураг, тайлбарыг онлайнаар гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд зөрчлийн тэмдэглэл үйлдэн тулган баримтжууллаа.

Аудитын дүн

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитаар 7 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 1 санал хүргүүлсэн болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор хүчингүй болгож, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” тогтоолыг шинэчилж баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлан мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталжээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоолоор аймаг болон сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 7,209.5 сая төгрөгөөр баталсныг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж орлогын шилжүүлгийн хэмжээг 470.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 7,680.0 сая төгрөг болгон баталсан байна.

2021 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 төсөл, арга хэмжээнд 4,659.8 сая, 19 сумын орон нутгийн хөгжлийн сангаас нийт 301 төсөл, арга хэмжээнд 3,020.2 сая төгрөгийг зарцуулахаар тус тус баталсан байна.

Бүлэг 1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. *Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.*

1.1.1. *ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?*

Орон нутагт хамаарахгүй.

1.1.2. *ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилж олгосон байна.*

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно”, 59.3.1 дэх заалтад “орон нутгийн хөгжлийн индекс”, 59.3.2 дахь заалтад “хүн амын тоо”, 59.3.3 дахь заалтад “хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ” гэж заасны дагуу ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилж олгосон байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд ОНХНС-аас 7,209.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлсныг тодотголоор нэмэгдүүлж 7,535.3 сая төгрөг болгон төлөвлөн батлсан байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2021 оны тодотгосон төсөв

Хүснэгт-1 /сая.төг/

Аймаг	Дотоодын НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМХТЗ	Урамшуулал	Дэмжлэг	Нийт
Увс	1,949.5	362.0	3,933.0	863.9	285.2	141.7	7,535.3

Эх сурвалж:/ Сангийн яамны 2021 оны 4-1/5768 тоот албан бичиг /

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө”, 6.2 дахь хэсэгт “Сум, дүүргийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө” гэж заасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив тусламж

Дээрх журамд заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын ИТХ-аар 2021 оны тухайн шатны төсвийг батлахдаа Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхой тусгаж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоолоор 2021 онд аймгийн ОНХС-д 4,287.0 сая, урсгал зардалд 402.0 сая, сумдын ОНХС-д 2,520.5 сая, нийт 7,209.5 сая төгрөгийг олгохоор анх баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгон баталсан 7,535.3 сая төгрөгөөс аймгийн ОНХС-д 4,515.1 сая, урсгал зардалд 402.0 сая, сумдын ОНХС-д 2,618.2 сая төгрөгийг хуваарилж, өмнөх оны үлдэгдэл 144.7 сая төгрөгийг нэмж нийт 7,680.0 сая төгрөгөөр баталжээ.

Дээрх тогтоолоор аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох санхүүжилт 4,515.1 сая, урсгал зардалд 402.0 сая, өмнөх оны үлдэгдлээс 144.7 сая, нийт 5,061.8 сая төгрөг болгон баталжээ.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, тогтоомжид заасны дагуу дараах байдлаар төлөвлөж бүрдүүлсэн байна.

Хүснэгт-2 /сая.төг/

№	Орлогын нэр төрөл	Аймаг		Сум	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	ОНХНС	4,515.1	4,515.1	2,150.4	2,150.4
2	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэг, урамшуулал			426.9	426.9
3	Үйл ажиллагааны орлого		176.1	358.6	325.6
4	Өмнөх оны үлдэгдэл	144.7	144.7	659.4	659.4
5	Урсгал зардал	402.0	402.0	40.9	40.9
	Нийт дүн	**5,061.8**	**5,237.9**	**3,636.1**	**3,603.1**

Эх сурвалж: /Үвс аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн алба/

Аймгийн ОНХС-д 176.1 сая төгрөгийн орлого гүйцэтгэлээр төвлөрсөн нь өмнөх оны хийгдээгүй ажлын санхүүжилтийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд буцаан төвлөрүүлэх акт тогтоосныг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр өмнөх оны үлдэгдэл 659.4 сая, үйл ажиллагааны орлого 358.6 сая, нийт 1,018.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.1.3. *Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.*

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дэх хэсэгт “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна” гэж заажээ. Үүнд:

- Энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;
- Энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

- Улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.
- Энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг дээрх хуульд заасны дагуу хуваарилсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт- 3 /сая.төг/

№	Үзүүлэлт	1. Хүн амын тооноос хамаарах		2. Алслалтаас хамаарах индекс /Шинэчилсэн/				3. Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах		Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн /30%/	АМХБАТ 3-ийн төлбөрийн 50%/50%/ 33%	Тогтвортой амжиргаа-3 төсөл		2021 онд олгох нийт дүн
	Сум	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Алслалт /км/	Хүн амын тоо	Алслалтын индекс = (Алслалт* хүн амын тоо)	Алслалтаас хамаарсан	Газар нутаг	Газар нутгаас хамаарсан			Урамшуулал	Дэмжлэг	
1	Баруунтуруун	2700	22.8	193	2700	521100	36.4	3300	24.7	83.90	0.77	0.0	6.8	91.5
2	Бөхмөрөн	2284	19.3	174	2284	397416	27.8	3700	27.7	74.76	15.49	0.0	6.1	96.3
3	Давст	1703	14.4	136	1703	231608	16.2	6300	47.2	77.78	28.48	16.6	6.3	129.2
4	Завхан	1843	15.5	161	1843	296723	20.7	6800	51.0	87.25	22.47	0.0	7.1	116.8
5	Зүүнговь	2778	23.4	139	2778	386142	27.0	4000	30.0	80.38	0.00	27.5	6.5	114.4
6	Зүүнхангай	2305	19.4	357	2305	822885	57.5	2600	19.5	96.40	1.11	33.0	7.8	138.3
7	Малчин	2494	21.0	99	2494	246906	17.2	4000	30.0	68.26	44.88	0.0	5.6	118.7
8	Наранбулаг	4266	36.0	90	4266	383940	26.8	5300	39.7	102.52	143.24	0.0	8.3	254.1
9	Өлгий	2417	20.4	113	2417	273121	19.1	2300	17.2	56.70	41.44	0.0	4.6	102.8
10	Өмнөговь	4626	39.0	109	4626	504234	35.2	3200	24.0	98.21	10.20	0.0	8.0	116.4
11	Өндөрхангай	3232	27.2	286	3232	924352	64.6	4700	35.2	127.05	16.33	27.2	10.3	180.9
12	Сагил	2463	20.8	61	2463	150243	10.5	3800	28.5	59.75	7.74	0.0	4.9	72.4
13	Тариалан	4022	33.9	30	4022	120660	8.4	3800	28.5	70.82	14.73	24.2	5.8	115.5
14	Түргэн	2150	18.1	36	2150	77400	5.4	2300	17.2	40.78	13.25	13.9	3.3	71.3
15	Тэс	5273	44.4	155	5273	817315	57.1	3100	23.2	124.78	0.00	0.0	10.2	134.9
16	Ховд	2456	20.7	177	2456	434712	30.4	3000	22.5	73.56	0.00	0.0	6.0	79.6
17	Хяргас	2585	21.8	163	2585	421355	29.4	3400	25.5	76.72	16.55	26.2	6.2	125.7
18	Цагаанхайрхан	2061	17.4	226	2061	465786	32.5	4000	30.0	79.90	33.01	27.3	6.5	146.7
19	Улаангом	30946	260.8	0	30946	0	0.0	30	0.2	26105	0.14	89.3	21.3	371.7
	НИЙТ ДҮН	82604	696.2	2705	82604.0	7475898	522.2	69630	522.2	1740.57	409.81	285.2	141.7	2577.3

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 8.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т зааснаас доошгүй хувь хэмжээгээр сум дүүргийн ОНХС-д хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1 болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилагдсан сум, дүүргийг мөн багтаан тооцно” гэж заасны дагуу ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилахдаа алслалт болон газар нутгийн хэмжээнээс тус бүр 30 хувь, хүн амын тооноос 40 хувиар хамааруулж тооцсон байна.

Аймаг сумдын ОНХС-д олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-4 /сая төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас олгосон санхүүжилт			
			Батлагдсан дүн /тодотголоор/	олгосон санхүүжилт	Зөрүү	Ирсэн санхүү-жилтийн хувь
1	Аймгийн ОНХС	8.9	4,515.1	4,515.1	0.0	100%
	Аймгийн дүн	**8.9**	**4,515.1**	**4,515.1**	**0.0**	**100%**
2	Баруунтуруун	18.6	91.5	91.5	0.0	100%
3	Бөхмөрөн	31.0	96.3	96.3	0.0	100%
4	Давст	18.7	129.2	129.2	0.0	100%
5	Завхан	13.0	116.8	116.8	0.0	100%
6	Зүүнговь	4.4	114.4	114.4	0.0	100%
7	Зүүнхангай	22.2	138.3	138.3	0.0	100%
8	Малчин	27.6	118.7	118.7	0.0	100%
9	Наранбулаг	74.5	254.1	254.1	0.0	100%
10	Өлгий	0.8	102.8	102.8	0.0	100%
11	Өмнөговь	4.1	116.4	116.4	0.0	100%
12	Өндөрхангай	90.5	180.9	180.9	0.0	100%
13	Сагил	4.2	72.4	72.4	0.0	100%
14	Тариалан	30.8	115.5	115.5	0.0	100%
15	Түргэн	19.7	71.3	71.3	0.0	100%
16	Тэс	142.1	134.9	134.9	0.0	100%
17	Ховд	6.6	79.6	79.6	0.0	100%
18	Хяргас	7.3	125.7	125.7	0.0	100%
19	Цагаанхайрхан	91.9	146.7	146.7	0.0	100%
20	Улаангом	51.4	371.7	371.7	0.0	100%
	Сумдын дүн	***659.4***	***2,577.2***	***2,577.2***	0.0	***100%***
	Урсгал зардал		442.9	442.9	0.0	100%
Аймаг, сумдын нийт дүн		***668.3***	***7,535.3***	***7,535.3***	***0.0***	***0.0***

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.9-д “ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй” гэж заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.1.4. *Сумдын ОНХС-д хуулийн хүрээнд нэмж 358.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.*

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг
- татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр
- тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг
- ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь
- малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-5 /сая.төг/

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас батлагдсан дүн /тодотголоор/	Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад	Нийт
1	Аймаг	8.9	4,515.1		4,524.0
2	Баруунтуруун	18.6	91.5	-	110.1
3	Бөхмөрөн	31.0	96.3	-	127.3
4	Давст	18.7	129.2	-	147.9
5	Завхан	13.0	116.8	31.4	161,2
6	Зүүнговь	4.4	114.4	-	118.8
7	Зүүнхангай	22.2	138.3	10.0	170.5
8	Малчин	27.6	118.7		146.3
9	Наранбулаг	74.5	254.1	21.0	349.6
10	Өлгий	0.80	102.7	38.0	141.5
11	Өмнөговь	4.10	116.4	40.2	160.7
12	Өндөрхангай	90.5	180.9	-	271.4
13	Сагил	4.2	72.3	-	76.5
14	Тариалан	30.8	115.5	96.1	242.4
15	Түргэн	19.7	71.3	-	91.0
16	Тэс	142.1	134.9	50.0	327.0
17	Ховд	6.6	79.5	67.0	153.1
18	Хяргас	7.3	125.7	4.9	137.9

19	Цагаанхайрхан	91.9	146.7	-	238.6
20	Улаангом	51.4	371.7	-	423.1
	Урсгал зардал		442.9		442.9
Аймаг, сумдын дүн		***668.3***	***7,535.3***	***358.6***	**8,562.1**

Эх сурвалж: /Сумдын ИТХ-ын тогтоолууд/

Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд дээрх хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж нэмж төлөвлөсөн эх үүсвэр байхгүй байна.

Харин 9 сумын ОНХС-д дээрх хуулийн 60.2.4, 60.2.8 дахь заалтад заасан эх үүсвэрээс нийт 358.6 сая төгрөгийн санхүүжилт оруулахаар төлөвлөсөн байна.

Сумдын Орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-6 /сая.төг/

д/д	Сумдын нэрс	Төсвийн тухай хуулийн 60.2.4 дэх заалт		Бусад орлого	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Завхан			31.4	15.6
2	Зүүнхангай			10	3.8
3	Наранбулаг			21	20.9
4	Өлгий	38	38		
5	Өмнөговь	30.2	4.4	10	10
6	Тариалан	96.1	61		
7	Тэс	50	50		
8	Ховд	58.9	45	8.1	11.7
9	Хяргас	4.9	4.9		
	Нийт	278.1	203.3	80.5	122.3

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Түүнчлэн аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд төлөвлөгдөөгүй дараах орлого төвлөрсөн байна. Тухайлбал: аймгийн ОНХС-д 179.1 сая төгрөгийн актын төлбөр, Бөхмөрөн, Давст, Зүүнговь, Өндөрхангай, Сагил, Тариалан, Түргэн, Хяргас, Цагаанхайрхан, Улаангом сумдын ОНХС-д нийт 60.2 сая төгрөгийн өвс, тэжээлийн үнэ болон бусад орлого төвлөрүүлсэн байна.

1.2. *Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумдын саналыг тусгасан эсэх нь нотлох бариmтаар тогтоогдохгүй байна.*

1.2.1. *Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумдын саналыг тусгасан эсэх нь нотлох бариmтаар тогтоогдохгүй байна.*

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”, Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар батлсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.3-д “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална”, 6.3.5-д “Иргэдийн оролцоог хангасан байх”, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар

тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтөлж сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна. Сумдын Засаг даргын Тамгын газар тухайн төсөл, арга хэмжээнүүдийг ач холбогдол, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд уялдуулан эрэмбэлж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 50 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авсан санал, холбогдох баримт материалыг ирүүлээгүй тул санал авсан эсэхийг тодруулахаар Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 05 дугаар сарын 11–ний өдрийн 374 дугаар албан бичгийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэхэд “Завхан сумын нийтийн халуун усны байрны засвар, өргөтгөл”, Зүүнхангай сумын хог, орчны тохижилт” гэсэн төсөл арга хэмжээний саналыг ирүүлсэн байна. Харин бусад сумуудаас санал авсан эсэхийг нотлох баримт байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг иргэдийн санал авахгүйгээр хэрэгжүүлсэн байна.

Цаашид орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахгүй байхыг зөвлөмж болгов.

1.2.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаал, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1 “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.1-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасан байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 351 төсөл, арга хэмжээг 8,176.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-7 /сая.төг/

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээний	
		тоо	мөнгөн дүн
1	Аймаг	50	4,659.7
2	Баруунтуруун	13	108.7
3	Бөхмөрөн	9	112.3
4	Давст	10	144.2
5	Завхан	9	161.2
6	Зүүнговь	9	118.1
7	Зүүнхангай	14	170.6
8	Малчин	15	146.3

9	Наранбулаг	18	355.9
10	Өлгий	10	140.8
11	Өмнөговь	22	160.7
12	Өндөрхангай	19	247.1
13	Сагил	14	75.4
14	Тариалан	20	236.7
15	Түргэн	4	81.3
16	Тэс	23	347.9
17	Ховд	15	153.7
18	Хяргас	11	138.0
19	Цагаанхайрхан	18	195.3
20	Улаангом	48	423.1
Нийт дүн		**351**	**8,176.9**

Эх сурвалж: /Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд/

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 4,659.7 сая төгрөгийн 50 төсөл, арга хэмжээг Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал, 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан эрэмбэлсэн байна.

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-аас Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй 10 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох;
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;
- Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;
- Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах;
- Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх;
- Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;
- Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох;

- Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;
- Аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт;
- Соёлын үйлчилгээ;
- Нийтийн биеийн тамир;
- Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэг хамаарахгүй дараах 4 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- “Ухаалаг Увс" application бий болгож иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх – 50.0 сая,
- "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл – 50.0 сая,
- "Хуримтлалтай иргэн" төсөл – 30.0 сая,
- Улаангом сумын орон сууцны хорооллын СӨХ-ийн менежмент – 149.0 сая,

Дээрх хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсэгт “Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Сумын удирдлагыг хэрэгжүүлэх;
- Сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;
- Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх;
- Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;
- Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;
- Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах;
- Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах;
- Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;
- Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Сумууд Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэг хамаарахгүй 6 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Завхан сум Иргэд ТАХ-ыг соён гэгээрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх – 1.5 сая,
- Малчин сум Сургалт сурталчилгааны зардалд- 0.6 сая,
- Өмнөговь сум Нүүдлийн штабын зардал– 3.0 сая,
- Сагил сум хуц уханд өвөлжөө барих – 2.0 сая,
- Цагаанхайрхан сум ЭМТ-ийн ХАНТР машины кроп, мотор солих, энгийн болгох-10.0 сая
- Цагаанхайрхан сум Сумын халуун усны чайнь,зуух солих -2.6 сая,

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.4 дэх заалт нь шинэчилсэн найруулгаар хүчингүй болсон байна.

1.2.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бусад хууль, журмын хүрээнд 30.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр “Ковид-19 цар тахлын PCR шинжилгээний өрөөний засвар”-ын ажилд 30.0 сая төгрөг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Бүлэг 2

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан ч "Шинэ хөдөө" төслийн хүрээнд 9.8 сая төгрөгийг дэмжлэгт, 102.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар сумдад болон төсөвт байгууллагуудад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороог байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Сангийн сайдын 2019 оны 281 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" -ын 2.13-д "Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дах хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон тохиолдолд батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх" гэж заасан байна.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлж болно", 4.1.1-д "Төсвийн тухай хуулийн 14.4-д заасныг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх", 4.1.2-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх" гэж заажээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 50 төсөл арга хэмжээнээс 17 төсөл, арга хэмжээний эрхийг харьяалах Төсвийн төвлөрүүлэн захирагч болон Төсвийн шууд захирагч нарт шилжүүлсэн байна. Үүнд:

1. *Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/08 дугаар захирамжаар 6 төсөл, арга хэмжээг*
    1. Хяргас сумын Хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах, 30.0 сая
    2. Өлгий сумын Спорт зааланд тоног төхөөрөмж худалдан авах, 40.0 сая
    3. Бөхмөрөн сумын Байрмын даваааны зам засах, 30.0 сая
    4. Хяргас сумын Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж худалдан авах, 30.0 сая
    5. Өндөрхангай сумын Үржлийн нэгжид дэмжлэг үзүүлэх, 30.0 сая
    6. Өмнөговь суманд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах, 30.0 сая

2. *Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн А/128 дугаар захирамжаар 6 төсөл, арга хэмжээг*
    1. Ховд сумын Шивийн гол орчмын авто замыг сайжруулах ажил, 50.0 сая
    2. Зүүнговь сумын багийн хоорондох замын зарим хэсгийг сайжруулах, 70.0 сая
    3. Малчин сумын Хар хэрмийн даваааны зам засах, 50.0 сая
    4. Давст сумын төвөөс Баруун гол хүртэлх замын зарим хэсгийг засах, 50.0 сая
    5. Зүүнхангай сумын хог орчны тохижилт, 30 сая
    6. Улаангом сумын 6-р багт ногоон байгууламж, тохижилт, 30.0 сая

3. *Аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн А/313 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг*
    1. Улаангом сумын 11-р багийн Халуун усны худагт ухаалаг төхөөрөмж суурилуулах, 10.0 сая

4. *Аймгийн Засаг даргын 2021 оны 8 дүгээр сарын 31-ний өдрийн А/494 дүгээр захирамжаар 1 төсөл, арга хэмжээг*
    1. Улсын бүртгэлийн хэлтэст Архивын нягтруулсан шүүгээ, 14.7 сая
    2. Улаангом сумын 4-р сургуулийн хоолны заалны засвар, 20.0 сая

5. *Аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/522 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг*
    1. Улаангом сумын 3-р багийн хог хаягдлын менежмент, 100.0 сая

6. *Аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/554 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг*
    1. Давст сумын төвийн тохижилт, 45.0 сая

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно”, 34.1.5 дахь заалтад “Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол” гэж заажээ.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс шалтгаалан дараах төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Улаангом сумын орон сууцны хорооллын СӨХ-ийн менежмент – 149.0 сая,

Увс аймгийн хэмжээнд 2021 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-8 /сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил				Нээлттэй тендер шалгаруулалт		Онцгой журам						Олон нийтийн оролцоотой худалдан авалт/зөвлөх үйлчилгээ/		Худалдан авах ажиллагаа зарлаагүй	
		Өмнөх оноос шилжсэн		Шинэ оны ажил				Хязгаарлагдмал тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС			50	4660	15	1706	0	-	30	2213.7	-	0	5	740		
2	Баруунтуруун	1	6.0	12	102.8	0	-	0	-	1	50.0	5	19.6	0	-	6	33.2
3	Бөхмөрөн	1	8.6	8	103.7	0	-	0	-	2	56.9	6	46.8	0	-	-	-
4	Давст	0	0.0	10	144.2	0	-	0		5	89.2	5	55.0	0	0	0	0
5	Завхан	1	6.2	8	154.9	0	-	0	-	2	65.0	4	68.5	0	-	2	21.5
6	Зүүнговь	1	9.0	8	109.1	0	-	0	-	2	52.7	6	56.4	0	0	0	0
7	Зүүнхангай сум	4	15.8	10	154.8	0	-	0	-	4	94.0	6	60.8	0	-	-	-
8	Малчин	0	0.0	15	146.3	0	-	0	-	2	41.9	13	104.4	0	0	0	0
9	Наранбулаг	2	7.9	16	348.0	1	130.0	0	-	13	210.1	-	-	0	-	2	7.9
10	Өлгий	1	2.4	9	138.3		-	0	-	2	94.0	7	44.3	0	0	0	0
11	Өмнөговь	1	1.8	21	158.9	0	-	0	-	2	72.0	8	41.3	5	14.8	6	30.8
12	Өндөрхангай	0	0.0	19	247.1	0	-	0	-	8	165.0	10	72.6	0	-	1	9.5
13	Сагил	1	7.5	13	67.9	0	0	0	-	0	-	13	67.9	0	0	-	0
14	Тариалан	1	18.6	19	218.1	1	40.0	0	-	3	35.3	6	64.3	0	-	9	78.5
15	Түргэн сум	0	0.0	4	81.3	0	-	0	-	1	64.0	2	16.2	0	0	1	1.1
16	Тэс	8	170.0	15	177.9	3	148.4	0	-	0	-	12	29.5	0	-	-	-
17	Ховд	2	33.0	13	120.7	0	-	0	-	1	55.0	11	57.3	1	8.4	-	-
18	Хяргас	0	0.0	11	138.0	0	-	0	-	3	70.0	8	67.9	0	-	-	-
19	Цагаанхайрхан	4	48.5	14	146.8	0	0	0	-	1	50.5	13	96.3	0	0	-	0
20	Улаангом	3	44.0	45	379.1	0	-	0	-	3	55.0	42	324.1	0	-		-
	Нийт	31	1558.0	320	7797.6	20	2,024.4	0	-	85	3,534.3	177	1,293.2	11	763.2	27	182.5

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба/

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 351 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд өмнөх оны 31 төсөл арга хэмжээ тусгагдсан байна.

Тайлант онд 320 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 293 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалт 20, харьцуулалтын арга 85, шууд гэрээ 177, олон нийтийн оролцоотой худалдан авалт /зөвлөх үйлчилгээ/ 11, огт хэрэгжээгүй 27 төсөл, арга хэмжээ байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ”, 19.2 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасныг зөрчин Сагил сум Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн 75.4 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт ажлын тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой тусгаагүй байна.

Цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ бүрд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой тусган боловсруулж байхыг зөвлөмж болгов.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, 21.4 дэх хэсэгт “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн

52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ", 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт "Хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулахдаа захиалагч энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд тендерийн урилгыг нийтэлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана" гэж заасныг зөрчин Давст сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилт 35.5 сая, Сумын нөөцөд өвс, тэжээл бэлтгэх 23.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг уламжлалт аргаар зохион байгуулсан байна.

Цаашид худалдан авах үйл ажиллагааг цахимд байршуулан сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах, иргэдийг мэдээллээр хангаж ажиллахыг зөвлөлөө.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан хэдий ч сумдын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн зарим нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна" гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Цаашид үнэлгээний хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хүмүүсээр бүрдүүлж байхыг зөвлөлөө.

Орон нутгийн өмчийн газар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, "Увс Орон нутгийн өмчийн газар" facebook хаяг, UVS.ONUG@G-mail цахим хаяг, МВС телевиз, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз болон Өглөөний сониноор олон нийтэд мэдээлсэн байна. Мөн 70453262 утсаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь заалтад "Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана" гэж заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг гаргаж 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална", 49.2 дахь хэсэгт "Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ" гэсэн заалтын дагуу тендерийн материалыг архивын нэгж болгосон байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд 102.3 сая төгрөгийг урсгал зардалд, 9.8 сая төгрөгийг дэмжлэгт олгосон байна.

Увс аймгийн хэмжээнд 2021 онд аймаг, сумдын ОНХС-ийн 8,176.9 сая төгрөгийн эх үүсвэрээр 351 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр аймаг, сумын ИТХ-аар батлсан байна.

Сагил сум 1.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулахгүйгээр хэрэгжүүлснийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоож биелэлтийг хангуулсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 351 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнөх оны 31 төсөл, арга хэмжээнд өмнөх онд гэрээ хийгдсэн бөгөөд тайлант оны 293 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг 7,240.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 267 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бүрэн, 26 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, 27 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн саналыг авсан байхаар хууль, журамд зохицуулсан байдаг.

Гэтэл тухайн орон нутгийн иргэд нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан өөрийн эрх ашигт хамааралтай жижиг ажлыг тусгуулах санал өгдөг, мөн аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр тойрог, тойрогтоо ОНХС-аас хөрөнгө хуваарилуулах зорилгоор төсөл, арга хэмжээг хэт их жижиглэж байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилгыг хангахгүй байх, бодит үр дүн, үр нөлөө багатай ажлууд төлөвлөгдөж хэрэгждэг асуудал жил бүр давтагдаж байна.

Иймд хууль, журамд өөрчлөлт оруулах замаар дээрх асуудлыг шийдвэрлүүлэхээр нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр дутуу хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-9 /сая.төг/

Д/д	Аймаг, сумдын	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, Дуусах хугацаа	Төсөвт өртөг	Ашиглалтад орсон эсэх /Комиссд хүлээлгэн өгсөн эсэх
1	Аймаг	"Шинэ хөдөө" төсөл	2021-2021	1,050.00	18 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс 11-р багцын ажлаас бусад ажлууд хэрэгжиж дууссан. Комисс ажиллах шаардлагатай ажлууд дээр комисс ажилласан.
2	Аймаг	Улаангом - Тэс чиглэлийн автозамын зарим хэсгийг сайжруулах ажлын зураг төсөв хийх	2021-2021	80.00	2021 оны 12 сарын 20-нд гэрээ байгуулсан, ажил дуусаагүй байгаа.
3	Аймаг	"Хашаандаа сайхан амьдаръя" төсөл	2021-2021	50.00	Ажлын даалгавар батлагдан, гүйцэтгэгчээр "Олон нийт байгаль хамгаалал бизнес эрхлэгчдэд зөвлөх сүлжээ" ТББ шалгарч, амьдрах орчны судалгаа, гэр хорооллын хашаанд барьж болох 40м2, 80м2 хувийн сууцны хувилбарт зургууд, 0.7га-ийн төлөвлөлтийн зураг, 7000ш гарын авлага хийгдсэн, "Хашаандаа сайхан амьдаръя-Увс" фэйсбүүк хуудас ажиллуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна. Комисс ажиллаагүй хүлээгдэж байгаа.
4	Аймаг	Тэс сумын төвд ухаалаг худаг	2021-2021	50.00	Ажил дуусаагүй, үргэлжилж байгаа.
5	Аймаг	Улаангом сумын орон сууцны хороололын СӨХ-ийн менежмент	2021-2021	149.01	Комисс ажиллаагүй хүлээгдэж байгаа.
6	Аймаг	Улаангом сумын 2,6,9-р багт ухаалаг худаг	2021-2021	135.00	6-р багийн худаг комисс ажиллаж хүлээн авсан. 2, 9-р багийн ажил дуусаагүй байна.
7	Аймаг	Улаангом сум дотор замын засвар, тэмдэглэгээ	2021-2021	80.00	АЖил дууссан. 5 сарын 31-нд комисс ажиллахаар захирамж гарсан
8	Аймаг	Давст сумын төвийн тохижилт	2021-2021	45.00	Ажил дуусаагүй, үргэлжилж байна.
9	Зүүнговь	Ухаалаг худаг	2021-2021	30.00	2021 онд ажил хийгдээгүй болно.
10	Хяргас	Сумны төвийн замын гэрэлтүүлэгийн засвар	2021-2021	19.03	Хүлээж аваагүй
11	Хяргас	Багуудын хүндэтгэлийн өргөө барих	2021-2021	30.00	Хүлээж аваагүй
12	Хяргас	Хүүхэд залуучуудын тоглоомын толбайн тохижилт	2021-2021	7.70	Хүлээж аваагүй
13	Хяргас	Захын гэр хорооллын харанхуй гудамжинд гэрэлтүүлэг тавих	2021-2021	4.30	Хүлээж аваагүй
14	Малчин	Гудамжны гэрэлтүүлэг	2021-2021	29.94	Дутуу хийгдсэн хүлээн аваагүй
15	Малчин	Баянмандал багт конторын барилга барих	2021-2021	13.00	Дутуу хийгдсэн хүлээн аваагүй
16	Наранбулаг	Цэцэрлэгийн тоглоомын талбай	2021-2021	15.00	Хүлээж аваагүй
17	Наранбулаг	Мал нядалгааны цэг бий болгох	2021-2021	20.00	Хүлээж аваагүй
18	Сагил	Зүүнмухар голоос шуудуй татаж ус гаргах	2021-2021	7.50	Хүлээж аваагүй
19	Сагил	Баруун хөвөө ус гаргаж шуудуй татах	2021-2021	7.50	Хүлээж аваагүй
20	Улаангом	Гэрэлт гудамжны тохижилт	2021-2021	9.80	Хүлээж аваагүй
21	Улаангом	Багийн тохижилт 11-р баг	2021-2021	9.50	Хүлээж аваагүй
22	Улаангом	Гэрэлт гудамжны гэрэлтүүлэг	2021-2021	3.00	Хүлээж аваагүй
23	Тариалан	Хүүхэд залуучуудын тоглоомын толбайн тохижилт	2021-2021	18.66	Хүлээж аваагүй
24	Зүүнхангай	Даланбулаг багийн байр шинээр барих	2021-2021	19.90	Хүлээж аваагүй
25	Тэс	Таван улиасны хог цэвэрлэх	2021-2021	2.00	Хүлээж аваагүй
26	Цагаанхайрхан	Халуун усны барилга шинээр барих	2021-2021	72.20	Дусаагүй, хүлээж аваагүй

/Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ/

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй дээрх төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч компаниар хийж гүйцэтгүүлэхийг зөвлөмж болголоо.

Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт ”Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 43.5 дахь хэсэгт “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2 дахь заалтад” төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл”, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах” гэж заасныг зөрчин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 8 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 752.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Уг асуудалд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгсөн болно.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоолоор “Шинэ хөдөө” төсөлд 1,050.0 сая төгрөг баталжээ. Үүнийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/23 дугаар тогтоолоор 18 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчин 102.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна. Тухайлбал:

- Увс аймгийн аялал жуулчлалын форум зохион байгуулахад – 5.1 сая,
- “Царгас” номын төлбөр- 1.0 сая,
- Шинэ хөдөө туршлага судлах ажилд -18.8 сая,
- “Увс түншлэл-2021” Чацарганын баяр арга хэмжээнд -2.9 сая,
- УБ хотод аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход -6.8 сая,
- ХАА-н үзэсгэлэн экспо зохион байгуулах, оролцох, сурталчлах, таниулахад -33.5 сая
- Мэдээлэл сургалт соён гэгээрүүлэх нөлөөллийн ажилд -19.5 сая,
- “Ургацын далай”, “Эргэх дөрвөн цаг” нэвтрүүлэг бэлтгэж МҮОНРТ-ээр цацахад – 5.0 сая,
- Улаангом сумын 128 чацаргана тариаланч иргэдэд 399.5 га талбайд цацах ургамал хамгааллын бодис 50 хувийн хөнгөлөлтэй үнээр олгоход – 9.7 сая, /нийт 19.3 сая төгрөгийн бодис олгосноос 9.6 сая төгрөгийг ОНХС-д буцаан төвлөрүүлсэн/

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал 4.2-т “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно” 4.2.4-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал”, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6-д “ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй”, 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэж заасныг зөрчиж аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд дэмжлэг хэлбэрээр тариаланчдад тараасан 9.8 сая

төгрөгийн өртөгтэй 610 кг улаан хальст саримсны үрийг Хүнс хөдөө аж ахуйн газрын дансанд авлагаар тусгуулах зөвлөмж өглөө.

Харин Тариалан сум 17.0 сая төгрөгийн 12 тонн тэжээлийн ургамлын болон арвай тарианы үрийг бэлтгэж сумын Засаг даргын тамгын газрын дансанд бараа материалаар бүртгэснээс 4.8 сая төгрөгийн үрийг иргэдэд олгосныг авлагаар тусгаж, 12.2 сая төгрөгийн үрийн үлдэгдэлтэй байна.

"Ухаалаг Увс" application бий болгож иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг 50.0 сая төгрөгөөр хэрэгжүүлж хүлээн авсан боловч уг application ажиллуулж эхлээгүй, иргэд мэдээллээ авч чадахгүй, ашиглалтгүй байгаа нь үр дүнгүй, үр ашиггүй ажил хийгдсэнийг харуулж байна.

“Хуримтлалтай иргэн” төслийг 30.0 сая төгрөгөөр хэрэгжүүлж хүлээн авсан боловч уг ажлын хүрээнд хийгдсэн ажлуудын нотлох анхан шатны баримт байхгүй, төсөл боловсруулж батлуулаагүй, зорилтот түвшин, хүрэх үр дүнг тодорхойлоогүй байна.

Дээрх 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулахаар шийдвэрлэв.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3 дахь заалтад “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” 14.3 дахь хэсэгт ”Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасан байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг авч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан тусгаж баталснаас шалтгаалан бүх төсөл, арга хэмжээний хувьд зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

Харин зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг тодорхойлох шаардлагатай томоохон ажлуудын хувьд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт дурдсан байна.

Цаашид төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодит тооцоо судалгаанд үндэслэн нарийвчлан тооцож баталснаар гарах үр дүн, үр ашгийг бодиттойгоор дээшлүүлэх боломжтой байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээ үр дүнгүй, 3 төсөл, арга хэмжээнээс үр дүн гараагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1.4-д “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ”, 4.1 “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ” гэж заасан байхад дараах ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс бодит үр дүн гараагүй байна. Тухайлбал:

- “Шинэ хөдөө-Увс” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн “Ирээдүйн сортыг нутагшуулах үр сорт худалдан авах”/Улаан хальст сармис/- 9.8 сая, /үрийг үнэ төлбөргүй тараасан, буцаан төлүүлэх талаар гэрээнд тусгаагүй, тариалсан хэдий ч ургаагүй/
- “Ухаалаг Увс” application бий болгож иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг дээшлүүлэх-50.0 сая, /зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй/
- Улаангом сум “Ахмад, залуучуудын байрыг засаж тохижуулах” – 9.0 сая /ажлыг дуусгаж хүлээлгэн өгсөн хэдий ч тухайн байрны засварын ажил хангалтгүй хийгдсэн, ашиглалтгүй/

Түүнчлэн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр тодорхой үр дүнгүй дараах ажлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- “Хуримтлалтай иргэн” төсөл- 30.0 сая,
- Малчин сум “Сургалт сурталчилгааны зардалд”-0.6 сая,
- Өмнөговь сум “Хортон шавьж сэг зэм, хог, нохой устгал хийх” -1.5 сая,
- Сагил сум “Хуц уханд өвөлжөө барих” -2.0 сая,
- Тэс сум “Айл өрхүүдэд мод тарихад дэмжлэг үзүүлэх” - 5.0 сая,

Цаашид орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлэхүйц төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхийг зөвлөлөө.

Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаангом сумын 10, 9, 12-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах”, 248.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаангом сумын ОБГ, Улаангом политехникийн коллеж, ББЭХС, ЦТС чиглэлийн бохирын шугам сүлжээний ажил эхлүүлэх” ажлууд нь иргэдийн амьдрах таатай орчин бүрдэх, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлэхээр байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байгаа хэдий ч “Шинэ хөдөө” төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг хоршоо болон иргэдэд түрээсгүйгээр ашиглуулж байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

Сангийн сайдын 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгасан бөгөөд ашиглалт хэвийн байна.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг иргэд болон хоршоонд түрээсгүйгээр ашиглуулж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.4.2 дахь заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасны дагуу аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн ашиглагч байгууллагын бүртгэлд тусгасан эсэхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тулган баталгаажуулахад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Улаангом сумын 7 дугаар багт гаргасан 48.9 сая төгрөгийн өртөгтэй ухаалаг худаг, Улаангом сумын 5 дугаар багт гаргасан 23.9 сая төгрөгийн өртөгтэй худаг бүртгэлд тусгаагүй, Өмнөговь суманд үйлдвэрлэлийн зориулалттай нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг өртгийг 3.4 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байсныг зөвлөмж өгч шийдвэрлэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэгт “Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ” гэж заасан байхад аймгийн Засаг дарга 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/488 дугаар захирамжаар “хөрөнгө хариуцан ажиллуулах нийтлэг түр журам” баталж иргэн, хоршоонд “Шинэ хөдөө” төслийн хүрээнд бий болсон газар тариалангийн зориулалтын трактор болон хүлэмжийг “хариуцан ажиллуулах гэрээ” байгуулан түрээсгүйгээр ашиглуулж байна.

Цаашид Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 60.1.6 дахь заалтад “аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болголоо.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/07 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг мөрдөж ажилласнаар орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Түүнчлэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд Өмнөговь суманд арьс шир боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч ашиглалтгүй хадгалагдаж байгааг ашиглалтад оруулахыг зөвлөлөө.

Бүлэг 3

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН ХЭДИЙ Ч ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна.

3.1.1. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, аймгийн ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 64.1.1 дэх хэсэгт “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих”, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2-д “Аймаг, нийслэл, сум,, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг”, 3.2.2-д ”Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/42 дугаар тогтоолоор байгуулсан ОНХС-ийн хяналтын хороо нь тодорхой үр дүнтэй ажил хийгээгүй, тус хорооны дарга болон 3 гишүүний албан тушаал өөрчлөгдсөн тул аймгийн ИТХ-ын даргын 2021 оны А/12 дугаар захирамжаар хяналтын хороог шинэчлэн байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын Төсөв санхүү, эдийн засгийн хорооноос 2021 онд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ болон аймгийн ГХБХБГ-тай хамтран Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлтэй танилцах, мөн аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Шинэ хөдөө-Увс“ төслийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ болон аймгийн ГХБХБГ, ХХААГ-тай хамтран гүйцэтгэлтэй танилцах удирдамжийг аймгийн ИТХ-ын дарга баталсан боловч хийсэн ажлын тайлан дүгнэлт байхгүй байгаа нь хяналтыг хууль, журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Цаашид хууль журамд тусгагдсан хяналтын үр дүнтэй хэрэгжүүлж байхыг зөвлөлөө.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй”, 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч дотоод аудиттай байх талаар болон дотоод аудитын чиг үүргийг тусгажээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь ОНХС-ийн 2021 оны зарцуулалтад тусгайлсан хяналт, шалгалт хийгээгүй байна. Улаангом сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд 2021 онд хийсэн хяналт, шалгалтаар ОНХС-ийн үйл ажиллагааг хамруулсан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ гэж заасан

байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс Ковид-19 цар тахлын тархалтын улмаас сумдад очиж ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. Харин сумдын 2021 оны ажлыг дүгнэхдээ ОНХС-ийн хэрэгжилтийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Цаашид ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст зөвлөмж болголоо.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хэрэгжүүлж байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.1-д, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.2 дахь заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.4-д заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана” гэж заасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 01/2021 дүгээр “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

Уг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үе шатны ажил болгон дээр хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж, чиглэл өгч ажиллажээ. Мөн төсөл, арга хэмжээнүүдэд аймгийн Засаг даргын улсын комисс ажиллуулах захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

3.1.3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн Хувь
1	Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.	100%
2	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.	100%
3	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсгийг мөрдөж тендерийн хавтаст хэргийг бүрэн бүрдүүлж, хяналт тавьж ажиллах.	100%
4	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг мөрдөж тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэний төлөөллийг оруулах.	100%
5	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг сумын Засаг даргын захирамжийг үндэслэн зарцуулах.	100%
Биелэлтийн дундаж хувь		**100%**

ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-13

№	Албан шаардлагын утга	Биелэлтийн хувь
1	Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 17708300 төгрөгийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
2	Наранбулаг сум нь орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй “Ковш трактор” 90000000, “Сургуулийн сурагчдын урлагийн хувцас” 6000000, “Соёлын төвийн сандал шинэчлэх” 10000000, “Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн зориулалтын хатуу эдлэл” 10000000 нийт 116000000 төгрөгийн төсөл арга хэмжээг ИТХ-аар баталж, санхүүжүүлсэн байна	100%
3	Сагил сум нь орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй “Хаман боогч трактор” худалдан авах ажлыг ИТХ-аар баталж 59500000 төгрөгөөр санхүүжүүлсэн байна.	100%
4	Улаангом сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд бэлтгэсэн 1500000 төгрөгийн 30 уут овьёосны хадгалалтын горим алдагдсанаас сумын онцгой комиссын шийдвэрээр акталж устгасан байна.	100%
5	Улаангом сум нь сумынхаа онцгой комиссын шийдвэрээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 1000000 төгрөгийн 100 боодол өвсийг 4 иргэний хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй олгосон байна	100%
6	Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр чөлөөлсөн 4, 11 багт байршилтай 83000000 төгрөгийн 4 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
7	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн “Орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг хүргэх ажил зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс сэтгүүл хэвлүүлэхээр “Ар идэр” ХХК-д 37400000, Цахим пресс ХХК-д 18000000, иргэн Б.Золзаяад 18000000 нийт 73400000 төгрөг шилжүүлж шууд худалдан авалт хийсэн байна	100%
8	Тариалан сумын Засаг даргын тамгын газарт худалдан авах PRIUS-20 машины техникийн тодорхойлолтод үйлдвэрлэсэн оныг 2012 гэж заасан байхад 2011 онд үйлдвэрлэсэн автомашин хүлээн авч орон нутгийн хөгжлийн сангаас 14900000 төгрөг зарцуулсан. Бургастай	100%

	багийн өвс тэжээлийн агуулах засварлах 9980000 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын техникийн тодорхойлолтод заасан өвс хадгалах байр, хашааны хэмжээ материалыг өөрчилсөн байна	
9	Малчин сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2019 онд бэлтгэсэн 8260000 төгрөгийн 1652 боодол өвс хадгалалтын горим алдагдсанаас сумын Засаг даргын хүсэлтийг үндэслэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт гарч Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор акталж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна	100%
10	Тэс суманд Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 30000000 төгрөгийн төсөвт өртөгтэй гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
11	Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 7/01 дугаартай тогтоолоор батлуулаагүй өмнөх оноос шилжих Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 16600000, Теле хяналтын төхөөрөмж 2000744, тайлант оны Соёлын төвийн тайзны хөшиг, тайзны хаалт хийх 12190825, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөний тохижилт 22680000, нийт 4 ажилд 53471569 төгрөгийг зарцуулсан байна	100%
12	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 83875362 төгрөгийн төсөвт өртөгтэй Улаангом сумын 12-р цэцэрлэгийн халаалтын тогоог данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
13	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 33000000 төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн архивын тасагт тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа шаардлагад нийцсэн 2 оролцогчийн тендерээс хамгийн бага үнэтэйг шалгаруулаагүй байна.	100%
14	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийг дансаар дамжуулан Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд 24600000 төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг, Спорт дэд хөтөлбөрийн хүрээнд Хөл бөмбөгийн холбоонд 2500000 төгрөгийн дэмжлэг өгсөн байна.	100%
15	Өлгий сум нь иргэдийн саналыг аваагүй, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулаагүй Ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламж барих 30000000 төгрөгийн ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлж, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж эргэж төлөгдөх зээлийн хэлбэрээр зарцуулан тайлагнасан байна.	100%
16	Давст сум нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Гэр хороллын гудамж талбайн гэрэлтүүлгийн кабель” 3000000 төгрөгийн 1500 метр сип утсыг хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй байна	100%
17	Биеийн тамир спортын газарт эрх шилжүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс Спортын дэд хөтөлбөрийн хүрээнд Хөл бөмбөгийн холбоонд 2400000, Үндэсний бөхийн холбоонд 5000000, Дугуйн холбоонд 1200000, Сагсан бөмбөгийн өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээний тамирчдын дэмжлэг 2000000, Өсвөр үеийн Үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 2000000, нийт 12600000 төгрөгийн дэмжлэгийг төрийн бус байгууллага, иргэнд олгосон байна	100%
18	Өлгий сум нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Ахмадын холбооны өрөөний тохижилт” 2000000, “Хөдөөгийн багт гар хийцийн 6 худаг сэргээн засварлах” 12000000, “Ухаалаг худаг” 12 900 000, нийт 26900000 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна	100%
19	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн “Орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг хүргэх ажил зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс сэтгүүл хэвлүүлэхээр “Ар идэр” ХХК-д 37400000, Цахим пресс ХХК-д 18000000, иргэн Б.Золзаяад 18000000 нийт 73400000, Жангар тууль хэвлүүлэхээр иргэн П.Батзаяад	100%

	9500000 нийт 82900000 төгрөгийг анхан шатны баримтын бүрдлийг хангуулахгүйгээр зарлагын гүйлгээ хийж шилжүүлсэн. Дээрх хөрөнгүүдийг хүлээн авсан акт байхгүй, орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.	
	Биелэлтийн дундаж хувь	100%

ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн актыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-14

№	Актын утга	Биелэлтийн хувь
1	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн санхүүжилтээс “Эрхзүйн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд Цахим хуудас идэвхжүүлэх нэрээр 1000000 төгрөг зарцуулснаас 855993 төгрөг хувь хүнд ашиглагдаж төрд хохирол учруулсан байна.	100%
2	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Өндөрхангай суманд бэлчээрийн худаг 30000000, Тэс сумын 150 ортой дотуур байрны хатуу зөөлөн эдлэл 20000000, Тэс суманд багийн төв барих 80000000, Тэс сумын 10,11 дүгээр багт мал угаалгын ванн барих, худаг засварлах 25000000 нийт 155000000 төгрөгийн 4 ажил хийгдэж эхлээгүй, гүйцэтгэл гараагүй байхад олгохоор төлөвлөн санхүүжилтийг барилгын барьцаа дансанд шилжүүлсэн байна.	100%
3	Санхүү төрийн сангийн хэлтэс нь Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг аймгийн ИТХ-аар батлагдсан дүнгээс 463171 төгрөгөөр илүү олгосон байна.	100%
4	Улаангом сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс, тэжээлийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийхэд 1566000 төгрөгийн өвс дутагдсан байна	100%
5	Наранбулаг сум нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүжилт 12000000 төгрөгийг зарцуулахгүйгээр сумын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.	100%
	Биелэлтийн дундаж хувь	100%

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж хүргүүлсэн байна.

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д “Сум дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана”

Журмын 9.9-д “Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана” гэж заасны дагуу аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс сумдын ОНХС-ийн 2021 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг нэгтгэж хүргүүлсэн

байна.

Мөн журмын 9.11-т ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ" гэж заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнасан байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.2 дахь заалтад "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "үнэн зөв байх" гэж заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн ашиглагч байгууллагын дансанд бүртгэж тайлагнасан байна.

3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалтад, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "ил тод байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ" Үүнд:

- 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
- 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;
- 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

- 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаа дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх гэж заасан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ”, 10.2.1-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас батлсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна” гэж заасан байхад Наранбулаг, Баруунтуруун, Зүүнговь, Өлгий, Сагил, Тэс, Хяргас сумууд мэдээлэл оруулаагүй, Цагаанхайрхан, Бөхмөрөн, Давст, Өмнөговь, Түргэн сумууд мэдээллийг дутуу оруулсан байна.

Журмын 10.2.3-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан батлагдсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.5 -д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ”, 10.3-д “Тухайн орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ОНХС-ийн УМС-ийг дараах байдлаар ашиглана” гэж заасныг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Цаашид аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын Засаг даргын тамгын газар Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд журамд заагдсан мэдээллийг оруулж, ашиглалтыг сайжруулж ажиллахыг зөвлөлөө.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д ”тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим

хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэж зааажээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх 4,659.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны нэгдсэн цахим сайтад мэдээлээгүй байсныг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад зөрчлийг арилгуулсан болно.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээнд иргэдийн санал аваагүй байна.

3. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 26 төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байна.

4. Сагил сум 75.4 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт хийгдэх ажлын тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой тусгаагүй байна.

5. Аймгийн Засаг дарга 2021 оны А/488 дугаар захирамжаар “хөрөнгө хариуцан ажиллуулах нийтлэг түр журам” баталсан байна.

6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд 102.3 сая төгрөгийг урсгал зардалд, 9.8 сая төгрөгийг дэмжлэгт олгосон байна.

7. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, аймгийн ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

8. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хэрэгжүүлж байна.

9. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж хүргүүлсэн байна.

Холбогдох байгууллагын санал

УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-2113
Цахим шуудан: info@khural.uv.gov.mn
Цахим хуудас: www.uvs.khural.mn

2022.06.06 № 283

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Уг тайланд аймгийн ИТХ нь орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хяналт хийсний үр дүнг нарийвчлан тооцох боломжгүй, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг баталсан зэрэг асуудалд цаашид анхаарч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА Ц.БАТБОЛД

F /disk/ хурлын албан тоот А5

УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2012, 7045-2315, Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2022.06.07 № 6/1027

танай _____ -ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төслийн 1.2.1-д "Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг аваагүй" гэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.3.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах чиг үүргийн дагуу сумын ЗДТГ, тухайн сумыг төлөөлж буй аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч нараар дамжуулан санал авч, нэгтгэн ОНХС-ын хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төслийг боловсруулсан.

Аймгийн 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумдаас 678 санал, аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчдөөс 380 санал ирүүлснийг хавсралтаар хүргүүлж байна.

ОНХС-д тусган хэрэгжүүлэхээр ирүүлсэн зарим саналаас дурдахад Баруунтуруун сумын ЗДТГ-аас "Шинээр 2 худаг нэмж гаргах", Бөхмөрөн сумаас "Гурванжигэртэй багийг өндөр хүчдэлийн шугамд холбох", Давст сумаас "Сумын төвийн ногоон байгууламж тохижилт", Цагаанхайрхан сумаас "Цэвэр усны машинтай болох", Өлгий сумаас "Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, спорт заалыг хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангах", "Бяцхан санхүүч", "Санхүүгийн эрсдэлээс сэргийлэх – Хуримтлалтай иргэн" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлэх, Тэс сумаас "Улаангом – Тэс сум орох элстэй хэсэгт зам засах", Улаангом сумын 4-р багийн төлөөлөгч Н.Батбаяр "Улаангом сумын 4-р багийн нутаг дэвсгэрт орших ЕБ-ын 4-р сургуулийн биеийн тамирын талбайг засаж, тохижуулж, сурагчдыг эрүүл аюулгүй орчинд суралцах боломжийг хангах", Ховд сумын төлөөлөгч Д.Хүрэлбаатар "Шивэрийн голд 7 км авто сайжруулсан зам тавих" зэрэг саналуудыг ирүүлсэн байна.

Аудитын тайлангийн төслийн Бүлэг 2-т "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашгийг тодорхойлоогүй байна." гэсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь Увс аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд туссан байдаг бөгөөд жилийн төлөвлөгөөний биелэлт, үр дүн нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэн 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 6/01 тогтоолоор Увс аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 84,01% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Тус үнэлгээнээс харахад Орон нутгийн хөгжлийн сангийн 50 төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ нь 90.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Хавсралт.....хуудастай.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭРДЭНЭТОГТОХ

D:\АЗДТГ\tamga A4.docx

8522020830

УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-3232, 7045-3262
Цахим шуудан: uvs.onug@gmail.com
Цахим хуудас: www.uvs.gov.mn/onug

2022. 06.06 № 136

танай 2022 0603 ны № 389 -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ё.МӨНХЗУЛ

D/Албан бичиг/ А5.docx

8822070137

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд дараах хариуг хүргүүлж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 283 дугаартай бичигт "...тайлангийн төсөлтэй танилцлаа. Уг тайланд аймгийн ИТХ нь орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хяналт хийсний үр дүнг нарийвчлан тооцох боломжгүй, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй зарим төсөл, арга хэмжээг баталсан зэрэг асуудалд цаашид анхаарч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно" гэсэн тул тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 6/1027 дугаартай бичигт тусгагдсан санал:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.3.1-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах чиг үүргийн дагуу сумдын ЗДТГ, тухайн сумыг төлөөлж буй аймгийн Иргэдийн Хурлын төлөөлөгч нараар дамжуулан санал авч нэгтгэн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төслийг боловсруулсан.

Аймгийн 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумдаас 678 санал, аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдөөс 380 санал ирүүлснийг хавсралтаар хүргүүлж байна.

ОНХС-д тусган хэрэгжүүлэхээр ирүүлсэн зарим саналаас дурдахад Баруунтуруун сумын ЗДТГ-аас "Шинээр 2 худаг нэмж гаргах", Бөхмөрөн сумаас "Гурван жигэртэй багийг өндөр хүчдэлийн шугамд холбох", Давст сумаас "сумын төвийн ногоон байгууламж, тохижилт", Цагаанхайрхан сумаас "Цэвэр усны машинтай болох", Өлгий сумаас "нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, спорт заалыг хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангах", "бяцхан санхүүч" санхүүгийн эрсдэлээс сэргийлэх хуримтлалтай иргэн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хашаандаа сайхан амьдаръя төслийг хэрэгжүүлэх, Тэс сумаас Улаангом-Тэс чиглэлийн элстэй хэсэгт зам засах, Улаангом сумын 4-р багийн төлөөлөгч Н.Батбаяр Улаангом сумын 4-р багийн нутаг дэвсгэрт орших ЕБ-н 4-р сургуулийн биеийн тамирын талбайг засаж тохижуулах, Ховд сумын төлөөлөгч Д.Хүрэлбаатар "Шивритийн голд 7 км сайжруулсан зам тавих зэрэг саналуудыг ирүүлсэн байна" гэжээ. Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулаа.

2. "Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь Увс аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байдаг бөгөөд жилийн төлөвлөгөөний биелэлт, үр дүн нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэгдэн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/01 тогтоолоор Увс аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 84.1 хувиар буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн. Тус үнэлгээнээс харахад ОНХС-ийн 50 төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ 90.2 хувьтай үнэлэгдсэн байна" гэжээ. Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулаа.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн 2022 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн 136 дугаар бичигт “...аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд санал байхгүй болно” гэсэн тул тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

1. Орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлахгүй байх.

Аймгийн Засаг даргад:

1. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 26 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.
3. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

1. ОНХС-ийн эх үүсвэрээр “Шинэ хөдөө” төслийн хүрээнд дэмжлэг хэлбэрээр иргэдэд олгосон 9.8 сая төгрөгийн улаан хальст саримсны үрийг авлагаар тусгах.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

Сагил сумын Засаг даргад:

1. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой тусган боловсруулж байх.

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

1. Орон нутгийн иргэд нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан өөрийн эрх ашигт хамааралтай жижиг ажлыг тусгуулах санал өгдөг, мөн аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр тойрог, тойрогтоо ОНХС-аас хөрөнгө хуваарилуулах зорилгоор төсөл, арга хэмжээг хэт жижиглэж байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилгыг хангахгүй байх, бодит үр дүн, үр нөлөө багатай ажлууд төлөвлөгдөн хэрэгждэг асуудал жил бүр давтагдаж байгааг хууль, журамд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР С.БАТСАЙХАН
АУДИТОР Ч.МӨНХТОГТОХ
Б.ЭНХМАНДАЛ